



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/680

Өлгий

**Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дугаар заалт, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаалыг тус тус үндэслэн, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, ажлын албыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн талаар холбогдох байгууллага, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэн сурталчилж, хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийг мөрдөж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын албанд /ЭМГ/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж явцын мэдээллийг хэлэлцэн холбогдох арга хэмжээ авч, 2018-2019 онд тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисст даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны оны А/66 дугаар захирамж, 2018 оны А/109 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 9-ний өдрийн 66 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ  А. КАМЕЛИЯТ




00001608

Аймгийн Засаг даргын 2018 оны
тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

- Комиссын дарга: -ЗДТГ-ын НБХ-ийн дарга
- Гишүүд:
- ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - ЗДТГ-ын НБХ-ийн эрүүл мэнд хариуцсан ахлах мэргэжилтэн
 - ЭМГазрын дарга
 - ЭМГазрын Эмийн аюулгүй байдал, чанар, тоног төхөөрөмж хариуцсан мэргэж
- А.Гулаза -Хүний их эмч, өндөр настан /Зөвшөлцснөөр/
- Нарийн бичгийн дарга -ЭМГ-ын Статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны
тоот захирамжийн хоёрдугаар хавсралт



АЖЛЫН АЛБАНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын албаны дарга:

-ЭМГазрын дарга

Гишүүд:

-ЭМГазрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн

-Эм, эмнэлгийн хангамж хариуцсан
мэргэжилтэн

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл,
эмнэлгийн магадлан итгэмжлэлийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

-Хүний нөөцийн төлөвлөлт, мэргэжлийн үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олголт
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

-Статистик мэдээлэл, тусгай зөвшөөрөл хариуцсан
мэргэжилтэн